


МОГОЙН ГОЛ ХК (BDL.MSE)

Салбар: Нүүрс олборлолт

2012.09.13



Үнэт цаасны үзүүлэлтүүд

Симбол	BDL
Хувьцааны код	444
Нийт гаргасан хувьцаа	829,622
Зах зээлийн үнэ (төгрөг) 2012.09.12	15,000
Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	12.4
52 долоо хоног- их/бага (төгрөг)	15500 / 32800

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

	2010	2011
Нийт хөрөнгө (тэрбум төг)	3.09	3.15
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)	0.03	0.02
Биет бус хөрөнгө ба өр төлбөр (тэрбум төгрөг)	0.39	0.40
Эзэмшигчийн өмч (тэрбум төгрөг)	2.23	2.24
Дансны үнэ (төгрөг)	3,258.5	2,341.8
Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг (төгрөг)	41.5	18.1
Үнэ ба ашгийн харьцаа (P/E)	195.07	2,039.7
Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B)	2.48	15.77
Хөрөнгийн өгөөж (ROA)	0.01	0.005
Эзэмшигчийн өмчийн өгөөж (ROE)	0.72	0.007
Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг (төгрөг)	5.00	-
Дундаж хувьцааны үнэ (төгрөг)	8,096.4	36,918.8
Дундаж зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	6.72	30.63

Эх сурвалж: Стандарт инвестмент ХХК

Могойн гол ХК-ийн хувьцаа нь 2010 оны II хагасаас 2012 оны II хагас хүртэл ТОП-20 индекст багтжээ.

Судалгааг хийсэн:

Цэдэвдорж ЧИМГЭЭ,

Судалгааны багийн ахлагч

chimgee@standardinvestment.mn

T +976 70114433

M +976 99066293

Бямбаа МӨНХТУЯА,

Судалгааны ажилтан

munkhtuya@standardinvestment.mn

T +976 70114433

M +976 99027432

КОМПАНИЙН ТОЙМ

Танилцуулга

Могойн голын чулуун нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 880 км, Хөвсгөл аймгийн Мөрөн хотоос 209 км, Завхан аймгийн Улиастай хотоос 226 км зайд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт оршино. Могойн голын нүүрсний уурхай 1971 онд ашиглалтад орсон, нийт 35 ажилчинтай. Одоогийн байдлаар нийт нүүрсний нөөцийн хэмжээ 11.4 сая тонн, компанийн эзэмшилд 84 га газар байдаг байна. Могойн гол ХК нь Хөвсгөл аймгаас гадна Завхан аймгийн төв болон зүүн чиглэлийн сумдыг эрчим хүчний нүүрсээр хангадаг. Завхан аймгийн нутаг дэвсгэрт нүүрсний орд байхгүй тул энэ аймгийн хатуу түлшний хангамжийн асуудал нь Могойн гол уурхайн үйл ажиллагаатай салшгүй холбоотой байдаг аж. Могойн гол ХК нь 1994 онд МХБ-д бүртгүүлсэн байна.

Менежмент

“Могойн гол” ХК нь нийт 829,622 ширхэг энгийн хувьцаа гаргасан. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийг дараах байдлаар харуулав.

Хувьцаа эзэмшигчид	Хувь
Төрийн өмч (Монгол Улс)	51%
Транс нефть ХХК (ОХУ)	15%
Ж.Батболд (ТУЗ-ийн гишүүн)	17%
Бусад	17%

Компанийн удирдлагууд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Очирхуяг

Мянганбуугийн Очирхуяг нь Хөвсгөл аймгийн Галт суманд 1979 онд төрсөн. 2001 онд МУБИС-ийг Биологич-байгаль шинжээч, багш мэргэжлээр, 2005 онд Энэтхэг улсын Дели хотын Компьютер менежментийн их сургуулийг вэб дизайнер мэргэжлээр төгссөн. 2002 оноос "Наран зангилаа" ХХК-ийн захирал, 2001-2003 онд "Далай ван" коллежид багш, сургалтын менежер, 2003-2005 онд Хөвсгөл аймгийн Байгаль орчны албаны дарга, 2005 оноос Хөвсгөл аймгийн Монгол Ардын Намын хорооны дэд даргаар ажиллаж байгаад 2008 оноос өнөөдрийг хүртэл Хөвсгөл аймгийн Засаг даргын орлогчоор ажиллаж байна. Мөн Могойн гол ХК-ийн ТУЗ-ын даргын үүргийг давхар гүйцэтгэж байна.

Гүйцэтгэх захирал Б.Хашбат

Б.Хашбат нь Завхан аймагт байрлах МУИС-ийн харъяа Эдийн засгийн сургуулийг төгссөн. Могойн голын нүүрсний уурхайд 10 гаран жил нягтлан бодогчоор ажиллаж байгаад, 2009 оноос өнөөдрийг хүртэл Могойн гол ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг хашиж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ



Монголын үндэсний статистикийн хорооны мэдээллээр манай улсын ДНБ-ийн мөнгөн дүн сүүлийн жилүүдэд өссөөр байгаа бөгөөд 2011 онд 8.4 их наяд төгрөгт хүрснээс уул уурхайн бүтээгдэхүүний мөнгөн дүн 2.2 их наяд төгрөг байжээ. Монгол Улсын нийт нүүрс үйлдвэрлэлийн хэмжээ 2011 онд 32 сая тонн байсан бол үүнээс төрийн өмчит нүүрсний уурхайн нийлүүлэлт 20 сая тонн, 2011 онд дотоодын нүүрсний хэрэглээ 6.8 сая тонн, экспортлосон нүүрсний хэмжээ 21.3 сая тонн болжээ. Ашигт малтмалын газрын 2012 оны нэгдүгээр сарын мэдээллээр эрчим хүчний нүүрс олборлогч компаниудын нийлүүлж буй нүүрсний үнэ 9,600-28,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан ба Могойн гол ХК-ийн нүүрсний үнэ 27,700 төг/тонн байжээ.

КОМПАНИЙН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ

Могойн гол ХК-ийн орд нь орон нутгийн эрчим хүчний стратегийн орд газар бөгөөд нүүрс олборлолтын жилийн хүчин чадал нь 35,000 тонн юм. 2011 онд 20,000 тонн олборлох төлөвлөгөөтэй ажиллаж, төлөвлөгөөгөө давуулан 23,000 тонн нүүрс олборложээ. Нүүрсний чанарын хувьд дунджаар 7,000 орчим ккал/кг илчлэгтэй коксжих нүүрс боловч тухайн бүст эрчим хүчний нүүрс олборлолт болон металлургийн үйлдвэр байдаггүйгээс коксжих нүүрсийг дулааны эрчим хүчинд ашигладаг байна. Коксжих нүүрсийг металлургийн үйлдвэрлэлд ашиглагддаг тул металлургийн нүүрс ч гэж нэрлэдэг байна. Могойн голын нүүрсний шинж чанарын үзүүлэлт нь “Ж”Маркийн хар өнгийн чулуун нүүрсний ангилалд багтдаг.

Чийг аналитик %	Үнслэг %	Хүхэр %	Илчлэг ккал/кг
5.4-9.0	7.4-27.9	0.74-1.33	5393-7055

Эх сурвалж: www.coalmining.mn

Компани нь коксжих нүүрсийг ОХУ, Хятад улс руу үйлдвэрлэлийн зориулалттайгаар экспортлохоор судалгаа хийж байна. Мөн Могойн голын нүүрсний уурхайг түшиглэн Завхан, Говь-Алтай аймгийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор 60 мегавт-ын хүчин чадалтай ДЦС барих шийдвэр гарч, Хятад улсын хөрөнгө оруулалттай “Шинэ Ази Майнинг” ХХК цахилгаан станцыг 2010-2011 онд барьж ашиглалтад оруулахаар Монгол Улсын ЗГ-тай гэрээ хийсэн ба 2011 оны 11-р сарын байдлаар ДЦС-ын барилгын ажил дуусаагүй байна. Могойн гол ХК-ийн эзэмшлийн газрыг давхардуулан 9,350 га газрыг “Хургатай хайрхан” ХХК-д олгосон ба “Хургатай хайрхан” ХХК нь тус ордыг Австралийн “Aspire Mining” ХК-д худалдсан талаарх мэдээлэл хэвлэл мэдээллээр цацагдсан байна. “Aspire mining” компани “Овоот” хэмээн нэрлэгдсэн энэхүү ордын ашиглалтын зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас авч чадах эсэхээс хамааран Могойн гол ХК-ийн ирээдүйн дүр зураг тодорхойлогдохоор байна.

ДҮГНЭЛТ

Могойн гол ХК-ийн (BDL) хувьцааны үнэ 2010 оны сүүлч, 2011 оны эхэн үеэс нэмэгдэн 2011 оны 2-р сарын 17-нд хамгийн дээд үнэ буюу 66,463 төгрөгт хүрсэн байна. BDL хувьцааны дундаж үнэ 2010 онд 8,096 төгрөг байсан бол 2011 онд 36,919 төгрөг болж өссөн байна. Ийнхүү BDL хувьцааны дундаж зах зээлийн үнэлгээ өссөн байна. Тухайн үед Aspire Mining компанийн Австралийн хөрөнгийн бирж дэх хувьцааны үнийн хэлбэлзэл BDL хувьцааны хэлбэлзэлтэй адил хэлбэлзэж байжээ. BDL хувьцааны үнийн өсөлтөөс хамааран үнэ ашгийн харьцаа (P/E) 2010 онд 195, 2011 онд 2,038 байжээ. ТОП-20 индексийн багцад багтах нүүрсний компаниудын үнэ ашгийн харьцааны дундаж болох 19.7-тай харьцуулахад BDL хувьцааны P/E харьцаа харьцангуй их байгаа нь хөрөнгө оруулагчид дэлхийн нүүрсний зах зээл дэхь Монгол Улсын байр суурийг өндрөөр үнэлж, компанийн хөрөнгө болон ашиг ихэснэ хэмээн хүлээсэнтэй холбоотой байж болно. Ногдол ашгийн хувьд компани нь хувьцаа эзэмшигчдэд 1996 оноос 2010 онд 1.0-7.62 төгрөгийн ногдол ашиг тараасан байна. Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B) нь 2010 онд 3.55 байсан бол 2011 онд 15.77 болж өсчээ. Энэ нь мөн BDL хувьцааны үнийн өсөлтөөс хамаарсан байна. Хөрөнгийн өгөөж (ROA) нь 2010 онд 1 хувь, 2011 онд 0.5 хувь, эзэмшигчийн өмчийн өгөөж (ROE) нь 2010 онд 1.5 хувь, 2011 онд 0.7 хувь байгаа нь компанийн менежментийн удирдлага ашигтай ажиллах тал дээр анхаараагүйг харуулж байна. Саяхан Ерөнхий сайд Н.Алтанхуяг нь төрийн өмчит уурхайн удирдлагуудтай уулзаж компаниудын үйл ажиллагааг сайжруулах тал дээр арга хэмжээ авахыг сануулсан тул компанийн менежментэд өөрчлөлт орох боломжтой юм. Гэвч BDL хувьцаа эзэмшихийг хүссэн хөрөнгө оруулагчдад нарт “Aspire Mining” ХК-д “Овоот” коксжих нүүрсний ордыг ашиглах лицензийг АМГ-аас өгөх эсэх шийдвэрийг хүлээхийг санал болгож байна.

Холбоо барих

Хаяг:

Стандарт Инвестмент ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Жигжиджавын гудамж 5/3

Шуудангийн хайрцаг:

Төв шуудан, Улаанбаатар 15160,

Хайрцагны дугаар 1487

Утас: +976 7011 4433

Факс: +976 7011 4433

www.standardinvestment.mn

info@standardinvestment.mn

Мэдэгдэл

[illegible][illegible]

© 2012 Standard Investment LLC

И И И А И Е	А И А Е Е	О А Е Е А А Д	А Е О Y Y Y
И Y A E O O A U O A A I A И I A A I O A O E A	EARNING PER SHARE - (EPS)	И y a e o o a u o a a i a и i a a i o a o e a и u y o a y e o y i a a a e a a i y a e o o a u o a a i a и i a a i a e a o e o y a y o a o a e e i o y i a y y и i. Y i y o a o u o a a e и и и a и e e i a o e a o a a e e e a a a a и u o o a e y y e y e o a e и a и a и y a e o o a u o a a i a и i a a i o a o e a o e i o y i a y y a e o и и i. E o y i o o i o e i a e a EPS - и и и o и e o a e e a и i a a и e a o e a o и e a и a a a e i a.	И y a e o o a u o a a i a и i a a i o a o e e a o i o и o и a и i a a o a o и i u, и a и i o o и i o и i.
И Y A A O A O A E E И O A D U O A A	PRICE TO EARNING RATIO -(P/E)	И y a o a e e i o a o u o a a a o o a u o a a и u c a o c y y e e e и i e e a и y a e o o a u o a a i a и i a a i o a o a e e i o y i a y y a o a a a e o i o и o a a y i y o a o u o a a и u e и и и a и e e i и o a o a e e i и o e i a u a c a o c y y e o o o и a o и o o e a a e a o y a y и o a o a o o c и y i y a e o a a e a a i a a a o a a a y e y i a a e a a a e e y o o e e e a y a. Y i y и u a a a a a e o o o n a i n a e i a y a e y a y a.	И y a o a e e i o a o u o a a a o i o и o и a и i a a o a o и i u, и a и i o o и i o и i.
А А И Н И U И Y	BOOK VALUE	А а и н и u и y a y a y a и e o o a e e i e и и a и e y e e a e e e a a a a a c и a и i и e и и a y o y a o a и u и y a e o o a u o a a i a и i a a i o o a e e a o i a и o i e e e i. и i a и n и u и i e e a c a o c y y e e e a и y o y e o a o u o o e a o o a u o a a и u и y i y e y y a и y a e a и e и i.	А а и н и u и e e a o i o и o и a и i a a a o o и u, и a и i o o и i o и i.
И Y A A Y Y Y И O E A x E E И a x E E И O A D U O A A	PRICE TO BOOK RATIO -(P/B)	И y a o o a u o a a и u c a o c y y e e e и i e e a a a и н и u и y a o o u o o e и a a o o a a o o a e e i e и и a и e e i o a u o a a и u и y и a o y n a y e a a a a и y i y e a a n y i e e a o a o o e и a. Y i y o a o u o a a и u и o y e и e o i e o и i a a e o o o n и a a n a e i a y a e y a y a.	И y a a y y и o e a a e e i и i e e i o a o u o a a a o i o и o и a и i a a o o и i u, и a и i o o и i o и i.
O o a и A E E И a A a a e	RETURN ON ASSET (ROA)	O o o и a e e e и a o a e и u и e e o o o и a e e e и y a o o a o a o o a и a и i a a и a a e a a a o y a y o a o a e e i o y i a y a e e y o o e e e и y. O o a e e i o o и i e e e a a o a e a a i и e и i o y a y o a o a e e i o y i a y y и a o o a a e o o n a i a a и a e i a a e a i a.	O o o и a e e e и a o a e e e a o i o и o и a и i a a a a o o и u, и a и i o o и i o и i.
Y Y Y И O E A x E E И a и x E E И a A a a e	RETURN ON EQUITY (ROE)	Y i y o a o u o a a и u o o a u a a y y c и o e a e e i o o o и a e e e и y a o a o o a i a и i a a и a e a o e e i o y i a y y a e e y o o e e e и y. a o o o o o y e a y e, e и и a и e o o и a o и o o e a a a a и и и a e e a a o a e a i o y o a o e a и e a a a e a a a e e y o o e e e и y. Y i y o a o u o a a e o a e e o o n a i n a e i.	O o o и a e e e и a o a e e a o i o и o и a и i a a a a o o и u, и a и i o o и i o и i.
			O o o и a e e e и a o a e e i o a o a e